

ХОРИХ ГАЗРААС СУЛЛАГДСАН ХҮНИЙГ ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ



Б.АЛТАНГЭРЭЛ

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал судалгааны профессорын багийн ахлагч, хууль зүйн ухааны доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

Товч агуулга. Энэхүү илтгэлээр хорих газраас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажлын өнөөгийн нөхцөл байдал, түүний онцлог, анхаарах асуудал болон цаашдын зохион байгуулалтад анхаарах асуудлын талаар судалгаанд үндэслэсэн саналыг гаргахыг зорьлоо.

Abstract: The presentation aims to offer an assessment based ideas on the current practice of social reintegration of released inmates, its features, current challenges and future issues on implementations.

Нэр томъёо. Хорих ял эдлүүлэх ажиллагаа, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын онцлог, хоригдлын сэтгэл зүй, хорих ялын онцлог

Key words: Enforcements of custodial sentences, characteristics of social reintegration of inmates, inmate psychology, characteristics of custodial sentences

Гадаад орнуудын туршлагаас харахад ялын сонгох хувилбарын хүрээг тэлж өргөжүүлэхийн тулд юуны өмнө тухайн орны эрүүгийн болон ял, шийтгэл гүйцэтгэх ажиллагааны тухай хуульд¹ нийгмээс тусгаарлахгүй ялыг² түлхүү тусгасан байх ба эдгээр арга замын нэг нь “нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл”-ын нэг төрөл буюу буюу “хорих ялын гүйцэтгэлийг хойшлуулах, хугацаанаас өмнө суллах” тухай ойлголт юм.

Уг ялыг тухайн этгээдийн зан үйл, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн төрөл, нийгэмд учруулсан сөрөг үр дагавар, хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж оногдуулдаг ба хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан, ялтныг эргэн

¹ Монгол Улсын хувьд уг хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай гэж нэрлэсэн байна.

² Монгол Улсын хувьд уг ялыг “хорихоос өөр төрлийн ял” гэж нэрлэсэн байна.

нийгэмшүүлэх боломжтой, эдийн засгийн хувьд хэмнэлттэй зэрэг давуу талуудыг дурдаж болно.

Олон улсын ял эдлүүлэх салбарт өргөнөөр хэрэглэгдэж буй социализация (орос), socialization (англи), sozialisierung (герман), ресоциализация, resocialization, resozialisierung, реабилитация, rehabilitation, social rehabilitation, rehabilitierung, sozialerehabilitierung, коррекция, исправление, адаптация гэсэн үг хэллэг-нэр томьёогоор илэрхийлэгдсэн “хоригдлыг нийгэмшүүлэх”, “хоригдолд нийгмийн ажлын, сэтгэл зүйн, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх”, “хоригдолд эрх зүйн нийтлэг журамд хүндэтгэлтэй хандах харьцааг төлөвшүүлэх”, “хоригдлыг суллагдсаны дараа бие даан амьдрах дадал, чадварт сургах” зэрэг нэр томьёо тусгагдан хэрэгжиж байна.

Түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг “нийгэмшүүлэх” гэж ярихаас гадна энэ үйл ажиллагаанд “эргэн /өөрчлөн/ нийгэмшүүлэх” гэсэн нэр томьёог ашиглах нь нийгэмшүүлэх ажлын агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлнэ гэж үздэг байна.

Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдлэгсдийн тоо жилд дунджаар 8.3-15.2 хувиар өссөн үзүүлэлттэй³, хорих ял эдлээд суллагдсан иргэдийн зүгээс давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй⁴, байна. Энэхүү статистик үзүүлэлтээс гадна ял эдэлж буй хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо хангалтгүй, хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй байгаа нь эрх зүйн зохицуулалтын болон зохион байгуулалтын шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Давтан гэмт хэргийг бууруулах, нийгмийн дэг журам, ялын гүйцэтгэлийн зорилгыг бүрэн хангахад хорихоос суллагдсан хүнд тавих хяналт, тэднийг нийгэмшүүлэх нь хамгийн чухал асуудал болоод байна.

Ял эдлүүлэх ажиллагааны гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар нийгэмд шударга байдлыг тогтооход оршино. Эрүүгийн ял, шийтгэлийг

³ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 2009-2017 оны тайлангаас үзэхэд жилийн эцсийн байдлаар нийт 5069-7083 ялтан ял эдэлж байжээ.

⁴2016 оны жилийн эцсийн дүнгээр нийт ял эдэлж буй хоригдогсдын 32 хувь нь 2-3 удаа гэмт хэрэг үйлдсэн, 16 хувь 4-ээс дээш удаа давтан гэмт хэрэг үйлдсэн байна.

тодорхойлсон эрх зүйн зохицуулалт болон ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд тулгуурлан ялын гүйцэтгэлийн бодлого тодорхойлогдох бөгөөд эрүүгийн ялын бодлогыг түшиглэн төрийн эрүүгийн бодлого бүрдэнэ.

Эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого гэдэгт төрийн зүгээс эрүүгийн ял шийтгэлийн зорилгыг тодорхойлох, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, ял, шийтгэлийн хэрэгжилтийг хангах болон шүүхээс ял оноосон этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг ойлгох ба дараах чиг үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Эрүүгийн ялыг гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэх;

2. Эрүүгийн ялыг гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэх (хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох);

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг сургаж хүмүүжүүлэх, хорих газраас суллагдсан хүнийг эргэн нийгэмшүүлэх зэрэг болно⁵.

Хорих байгууллагаас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажиллагааны онцлог, анхаарах асуудал

Хорих ялтай холбоотой нийгэмшүүлэх ажлыг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

а/ Хорих ял эдлүүлэх ажиллагааны хүрээнд явагдаж буй нийгэмшүүлэх ажил нь 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218, 219 дүгээр зүйл, 2018 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Нийгмийн ажлын аргачилсан заавар;

б/ Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шийдвэрийг биелүүлэх үеийн хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 185-189 дүгээр зүйл;

в/ Шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа дуусч суллагдсан этгээдийн хяналтыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 болон 41-45 дүгээр зүйлийн хүрээнд зохицуулж байна.

⁵ Б.Алтангэрэл.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа:харьцуулсан судлал.УБ.,2018.19 дэх тал

Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд суллагдсан этгээдтэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь “хяналт”-аар хязгаарлагдаж буй нь тэднийг хэн, хэрхэн нийгэмшүүлэх асуудлыг орхигдуулжээ.

Дэлхийн ихэнхи оронд хорих ял эдлээд суллагдсан этгээдэд үзүүлэх нийгэмшүүлэх ажлыг тухайн иргэнийг нийгмийн харилцаанд оролцогч гэдэг утгаар нь дараах үндсэн хэлбэрүүдээр явагдаж байна.

1. Нийгмийн харилцаанд эрх зүйн дэг журмыг мөрддөг, бие даан амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдсэн амьдрах ухааны болон боловсрол, мэргэжил, хөдөлмөрийн дадлага олгох “СУРГАЛТ”-ад хамруулах;

2. Тухайн хүний ур чадвар, хүсэл, сонирхлыг харгалзан тогтвортой ажлын байраар хангахад чиглэсэн “ЗУУЧЛАХ” үйлчилгээг явуулах;

3. Суллагдсан хүний хувийн болон санхүү, гэр бүлийн байдал зэргийг харгалзан “НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН” үйлчилгээнд хамруулах зэрэг болно.

Дээрх ажил үйлчилгээнд суллагдсан этгээдийг тэгш хүртээмжтэй хамруулснаар нийгэмшүүлэх ажлын үр дүн нэмэгдэн, дахин гэмт хэрэг буурах, улмаар хүний эрх, эрх чөлөө бүрэн утгаар хангагдах учиртай.

Монгол Улсын хэмжээнд хорих ялтай холбоотой ялын гүйцэтгэлийг хойшлуулсан, тэнссэн, хугацаанаас өмнө сулласан судалгааг сүүлийн 5 жилээр авч үзвэл:

1. Шүүхээс 2014 онд 6277 хүнд хорих ял оногдуулснаас 2441 хүнд биечлэн эдлүүлж, 3396 хүнийг тэнсэн, 434 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2015 онд 5257 хүнд хорих ял оногдуулснаас 2070 хүнд биечлэн эдлүүлж, 3197 хүнийг тэнсэн, 365 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2016 онд 5114 хүнд хорих ял оногдуулснаас 1823 хүнд биечлэн эдлүүлж, 2866 хүнийг тэнсэн, 303 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2017 онд нийт 4596 хүнд хорих ял оногдуулснаас 2192 хүнд биечлэн эдлүүлж, 2045 хүнийг тэнсэн, 310 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2018 онд нийт 3245 хүнд хорих ял оногдуулснаас 2995 хүнд биечлэн эдлүүлж, 132 хүнийг тэнсэн, 111 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан⁶ судалгаа байна.

2. Хорих байгууллагаас 2014 онд-2065 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-440 нь, хугацаанаас өмнө-1585, ерөнхийлөгчийн зарлиг,

⁶ Б.Алтангэрэл. Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018. УБ., 2019 он. 59 дэх тал

ялын өөрчлөлт, өвчний учир-40, 2015 онд-3445 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-428, хугацаанаас өмнө-1167, өршөөлийн хуулиар-1778, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-72, 2016 онд-1334 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-310, хугацаанаас өмнө-997, өршөөлийн хуулиар-6, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-21, 2017 онд-2918 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-396, хугацаанаас өмнө-1115, хуулийн тэгшитгэлд-1342, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-65, 2018 онд-1813 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-702, хугацаанаас өмнө-1068, хуулийн тэгшитгэлд-20, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-23 хүн тус тус суллагдаж байсан байна⁷.

Кейс.1.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч О... Монгол Улсын хэмжээнд суллагдсан хүнийг нийгэмшүүлэх асуудал нь зөвхөн захиргааны хяналтын хүрээнд явагдаж байгаа, Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтан Б...суллагдсан хүнтэй сард 1 удаа уулзаж бүртгэл хөтөлдөг.

Монгол Улсын өнөөгийн практикт хугацаанаас өмнө суллах, тэнсэх, ял хойшлогдсон хүнд тавих хяналт, нийгэмшүүлэх ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих ялын хугацаа дуусч суллагдсан хүнд тавих хяналт, нийгэмшүүлэх асуудлыг Цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэж байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/247, А/167/303 дугаар хамтарсан тушаалаар хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэгч нийслэлд 160, орон нутагт 120 ялтан, этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудсанд хяналт тавиж ажиллахаар жишиг нормативийг батлан тогтоосон. 2019 оны байдлаар 1 эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч орон нутагт 250, нийслэлд 360 этгээдэд хяналт тавин ажиллаж байна.

Эндээс харахад суллагдсан хүнийг нийгэмшүүлэх нь зөвхөн дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэсэн үндэслэлээр дуудаж уулзах, хянах байдлаар явагдаж байна.Өөрөөр хэлбэл “ХЯНАЛТ-НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛ”-ын харьцаа алдагдсанаар суллагдсан этгээдийг эргэн нийгэмшүүлэх ажил үр дүнтэй явагдахгүй байна.

⁷ Хоригдогчдын шилжилт, хөдөлгөөн, дүн бүртгэлийн тасгийн тайлан, мэдээ

Түүнчлэн суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, оролцоог хуульчилсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхтэй холбоотой Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тусдаа өөр өөрсдийн хууль, журам, зааврын хүрээнд гүйцэтгэгдэгээс болж байна.

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль зүйн салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг бүх нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй, хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй байгаа нь бие даасан эрх зүйн зохицуулалтын болон бүтцийн шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай холбон өөрчлөх, гадаадын бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааны туршлагад суурилан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэн хөгжүүлэх нь зүйтэй юм.

Илтгэлийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 40 эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нараас суллагдсан иргэнд тавих хяналт, нийгэмшүүлэх ажлын үр дүнгийн талаар судалгаа авахад сайжруулах шаардлагатай гэж 60 хувь, шаардлага хангахгүй байна гэж 35 хувь нь үзсэн нь хангалтгүй байгааг илтгэн харуулж байна.

Иймд суллагдсан хүнийг эргэн нийгэмшүүлэхтэй холбоотой дараах саналыг гаргаж байна.

1. Дэлхийн улс орнуудад хэрэглэгдэж буй хорих ял хойшлогдсон, суллагдсан зэрэг хүнийг нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий "Пробаци"-ын албаны үйл ажиллагааг Монгол Улсад нэвтрүүлэх.

2. Улс орны хэмжээнд нийгмийн ажлын ерөнхий хуулийг батлан, тухайн хуульд хорих ял эдлээд суллагдсан хүнийг нийгэмшүүлэх асуудлыг хуульчлах.

3. Суллагдсан хүнийг нийгэмшүүлэхэд зөвхөн төрийн байгууллагын хүчээр бус хувийн хэвшил, иргэдийн оролцоо нэн чухал гэдэгтэй санал нийлэн, энэ хүрээнд хууль тогтоомж, зохион байгуулалтын арга хэмжээ авах зэрэг болно.